



БАЯНТАЛ СУМЫН ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2017 ОНЫ НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
доорх хаягаар харилцана уу:

Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа
Утас: 70543156
Цахим хаяг: sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер Г.Наранбаяр
Утас: 70543179
Цахим хаяг: naranbayarg@audit.gov.mn
Ахлах аудитор Ц.Батсайхан
Утас: 70543151
Цахим хаяг: Batsaikhants@audit.gov.mn
Хаяг:
Сүмбэр сум, 3 дугаар баг, Нутгийн
удирдлагын ордон 2 дугаар давхар

Аудитын тайлан

АГУУЛГА

- Аудитын гэрчилгээ
- Менежментийн захидал
- Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

| | |
|--|----|
| Товчилсон үгийн жагсаалт | 2 |
| Нэг. Ерөнхий зүйл | |
| Аудит хийсэн үндэслэл, хугацаа..... | 5 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ..... | 5 |
| Аудитын арга зүй..... | 5 |
| ОН-ийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал..... | 5 |
| Хоёр. Санхүүгийн дотоод хяналт..... | 6 |
| Гурав. Шилэн дансны мэдээлэл..... | 7 |
| Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох..... | 8 |
| Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар..... | 8 |
| Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал | |
| 6.1. Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар | 8 |
| 6.2. Арилжааны банкин дахь орон нутгийн харилцах дансны талаар..... | 9 |
| 6.3 Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлын талаар..... | 10 |
| Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал | |
| 7.1. Авлагын бүтцийн талаар..... | 11 |
| 7.2. Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар авлагын бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар..... | 12 |
| Найм. Бараа материалын бүртгэл, тайлагнал | |
| 8.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар | 14 |
| 8.2 Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгий тайланд хийсэн аудитаар бараа материалын зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар..... | 14 |
| Ес. Үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагнал | |
| 9.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын | |

| | |
|---|----|
| талаар..... | 15 |
| 9.2 Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар | 17 |
| Арав. Өр төлбөрийн бүртгэл тайлагналын талаар | |
| 10.1. Өр төлбөрийн бүтцийн талаар..... | 18 |
| 10.2. Өр, төлбөрийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар..... | 19 |
| Арван нэг. Орлогын бүртгэл тайлагнал | 20 |
| 11.1 Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар | 21 |
| 11.2 Мөнгөн гүйлгээний тайлангийн болон төсвийн гүйцэтгэлийн орлогын талаар..... | 21 |
| 11.3 Бусад эх үүсвэрийн талаар..... | 24 |
| Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал..... | 25 |
| 12.1 Зардлын бүтцийн талаар | 26 |
| 12.2 Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар төсвийн зарцуулалт, бүртгэл,тайлагналтай холбоотой зөрчлүүдийн талаар..... | 28 |
| Арван гурав. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар | 25 |
| Арван дөрөв: Хуримтлагдсан үр дүнгийн талаар..... | 26 |
| Арван тав: Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл | 26 |
| Арван зургаа: Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт..... | 26 |
| Арван долоо.Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн санал, дүгнэлт..... | 26 |
| Арван найм.Аймгийн СТСХ-ийн даргад уламжлах санал | 27 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| УИХ | Улсын Их Хурал |
| СЯ | Сангийн яам |
| ААН | Аж ахуйн нэгж |
| ААНБ | Аж ахуйн нэгж байгууллага |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| АИТХ | Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| НББ | Нягтлан бодох бүртгэл |
| НББОУС | Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| СТОУС | Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн ОУС |
| ОН | Орон нутаг |
| ХО | Хөрөнгө оруулалт |
| ОНХО | Орон нутгийн хөрөнгө оруулалт |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн хурал |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ОННСТ | Орон нутгийн нэгтгэсэн санхүүгийн тайлан |
| СНТ | Нэгтгэсэн санхүүгийн тайлан |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТЕЗ | Төсвийн ерөнхийлөн захирагч |
| АМНАТ | Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр |
| АТБӨЯХ | Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл |
| ХХОАТ | Хувь хүний орлогын албан татвар |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ОНӨҮГ | Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар |
| ХХААГ | Хүнс, хөдөө аж ахуйн газар |
| ХЭДС | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| СХС | Сум хөгжүүлэх сан |
| МХС | Мал хамгаалах сан |
| БХС | Байгаль хамгаалах сан |
| ЖМС | Жижиг мөнгөн сан |

Нэг. Ерөнхий зүйл

Аудит хийсэн үндэслэл, хугацаа

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3-т заасан аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд /ГСА-2018/02-СТА-ТТЗ/ аудит хийлээ.

Аудитын зорилт, хамарсан хүрээ

Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт болон бусад шаардлагын дагуу бэлтгэж, ажил гүйлгээ нь түүнийг зохицуулж буй хууль, тогтоомжийн хүрээнд хийгдэж, үнэн шударга илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангууд иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг бүрэн ирүүлсэн бөгөөд эдгээр мэдээллийг Аудитын олон улсын стандартын дагуу сорьж шалгах нь аудитын зорилт болно.

Төсвийн тухай болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай шилжүүлгийн байгууллагууд, санхүүгийн тайлан, төсөл сангуудын нийт 11 тайланг хамруулан нэгтгэсэн тайланг аудитласан болно. Үүнд:

- Орон нутгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлан 2
- Тусгай зориулалтын шилжүүлгийн төсөвт байгууллагын санхүүгийн тайлан 4
- Төсөл, сангуудын санхүүгийн тайлан 5

Аудитын арга зүй

Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй баталгаа олж авахын тулд санхүүгийн тайланг бэлтгэхэд баримталсан бодлого, зарчмыг үнэлж, хяналтын сорил, шинжилгээний горим болон нарийвчилсан сорил хийж, ихээхэн дүнтэй ажил гүйлгээ, тооцооллыг давтан шалгаж, санхүүгийн тайлан, түүний тодруулгад үнэлгээ өгөв.

Ингэхдээ санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг үндсэн шалгуур болголоо.

Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланг нэгтгэхэд баримталсан бодлого, аргачлал

Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ УСНББОУС-д заасан зарчим, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалыг баримтлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1, 6.1 дэх заалтуудын дагуу нягтлан бодох бүртгэлийн тохируулсан аккрузал суурийг хэрэглэж, Монгол Улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж гаргасан байна.

Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

| А. Үндсэн тайлан: | Б. Байгууллагын төрлөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан | В. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тайлбар, тодруулга |
|--|---|---|
| Санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан | Байгууллагын төрлөөрх санхүүгийн байдлын тайлан | Үндсэн хөрөнгө, бараа материал, өр, авлагын тодруулга тайлан байгууллагын төрлөөр |
| Санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан | Байгууллагын төрлөөрх санхүүгийн үр дүнгийн тайлан | |
| Мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан | Байгууллагын төрлөөрх мөнгөн гүйлгээний тайлан | |
| Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан | Байгууллагын төрлөөрх цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | |

Дээрх тайлангуудаас Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлангаас бусад тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан, тэмдэглэл бэлтгэх аргачлал”-ын дагуу “Э-тайлан” програмаар бэлтгэн гаргажээ.

Хоёр. Санхүүгийн дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, дотоод аудитыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Санхүүгийн хяналт, аудитын алба” нь 2017 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсны дагуу Баянтал сумын ЗДТГ, 4 дүгээр сургуульд хяналт шалгалт хийсэн байна

Баянтал сумын 4-р сургуулийн үйл ажиллагаанд хийсэн хяналт шагалтаар дараахь зөрчил илэрсэн байна. Үүнд:

- Тухайн байгууллага нь 2015 оны жилийн эцэст цалингийн урьдчилгааны авлагыг 1,566.0 мянган төгрөгөөр илүү тайлагнасан байна.

- 2016 онд нэр бүхий ажилтнуудаас нийт 4262,8 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг суутгаагүй бөгөөд тайлан балансад 759,4 мянган төгрөгийг авлагад тусгаад үлдэгдэл 3503,4 мянган төгрөгийг авлагад тусгалгүй шууд зардалд хаасан
- Д.Өсөхбаяр нь шүүхийн суутгалтыг 400.0 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн
- 2016 онд үйлдвэрчний эвлэлийн суутгалыг 74,2 мянган төгрөгөөр илүү шилжүүлсэн
- 2016 онд шилэн дансны мэдээ оруулалт хангалтгүй байсан бөгөөд мэдээллийг нөхөн оруулсан шалгалтаар нийт 6,303.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлснээс 3977,6 мянган төгрөгийг орон нутгийн орлогод оруулахаар төлбөрийн акт тогтоож, цалингийн урьдчилгааны авлагаас 1566,0 мянган төгрөгийг нь нягтлан бодох бүртгэлийн алдааг залруулахаар, 759,4 мянган төгрөгийг нь 2018 оны 1 дүгээр сард барагдуулулахаар улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна.

Баянтал сумын ЗДТГ-ын аймгийн Дотоод Аудитын Хорооны 2017 оны 03 дугаар сарын 14 хуралдаанаар өгөгдсөн үүргийн дагуу Баянтал сумын ЗДТГ-ын 2011-2016 оны цалингийн урдчилгааг түүвэрлэн шалгалаа.

Шалгалтаар нийт 12 ажилтантаас 2,493.8 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааг дутуу суутгаж, 1,825.2 мянган төгрөгийн урьдчилгааг авлагаар тусгаж, 668.6 мянган төгрөгийн урьдчилгааг шууд зардалд хаасан байна.

Нийт 668.6 мянган төгрөгийг нөхөн төлүүлэхээр акт тогтоож, 1,825.2 мянган төгрөгийн авлагыг барагдуулахаар хугацаатай албан шаардлага хүргүүлсэн байна.

Гурав. Шилэн дансны мэдээлэл

Говьсүмбэр аймгийн Баянтал сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Шилэн дансны хуультай холбоотой байж болох эрсдэлийн хүчин зүйлсийг судлах явцад 11 эрсдэлтэй асуудал тогтоогдож, 11 горим сорил хэрэгжүүлэв.

Тус сум нь Шилэн дансны хуулийн дагуу нийт 149 мэдээлэх оруулахыг бүрэн оруулсан бөгөөд нийт оруулсан мэдээллийн 41.6% буюу 62 мэдээллийг хугацаа хоцроосон байна.

Дөрөв. Материаллаг байдлыг тодорхойлох

Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлыг 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын дүнг суурь болгон авч түүний 1.0%-иар тооцон 18,425.1 мянган төгрөгөөр тогтоов.

Тав. Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаар

Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд орон нутгийн төсөвт байгууллага, тусгай шилжүүлгийн байгууллага, төрийн сан, сангуудын нийт 11 байгууллагын тайланг хамрууллаа.

Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан иж бүрэн бөгөөд үнэн зөв болохыг тодорхойлсон батламж мэдэгдэл, тайлбар, нэмэлт тодруулгыг хавсарч ирүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг ирүүлэхээр заасан боловч Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газарт 2018.03.13-ны 97 тоот албан бичгээр ирүүлсэн бөгөөд хуулийн хугацааг 8 хоногоор хоцроосон болно.

Зургаа. Мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал

6.1 Мөнгөн хөрөнгийн бүтцийн талаар

Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгөд дараах зүйлсийг бүртгэж тайлагнасан байна. Үүнд:

- Сумын ерөнхий орлогын данс
- Орон нутгийн төрийн сангийн дансны үлдэгдэл, арилжааны банкуудад байршдаг зарим төсвийн байгууллагын нярвын данс, харилцах дансдын үлдэгдэл, ОНӨААТҮГ-ууд болон төсөл сангийн үлдэгдэл,
- ОНӨААТҮГ-уудын кассад байгаа бэлэн мөнгөний үлдэгдэл

Баянтал сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 2017 оны эхэнд 303,350.1 мянган төгрөг байсан ба тайлант оны эцэст 102,954.4 мянган төгрөг болж 66%-иар буюу 200,395.7 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт үлдэгдэл нь төрийн сангийн нэгдсэн дансанд байршиж байна.

Баянтал сумын мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн 2017 оны үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

(мян.төгрөгөөр)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Кассад байгаа бэлэн мөнгө | Банкинд байгаа бэлэн мөнгө | |
|----------------------------------|------------------|------------------|---------------------------|----------------------------|-----------------------------|
| | | | | Арилжааны банк | Төрийн сангийн нэгдсэн данс |
| Банкинд байгаа бэлэн мөнгө | 303,351.1 | 102,954.4 | 0.0 | 0.0 | 102,954.4 |
| Төгрөг | 303,351.1 | 102,954.4 | 0.0 | 0.0 | 102,954.4 |
| Нийт мөнгөн хөрөнгийн дүн | 303,351.1 | 102,954.4 | 0.0 | 0.0 | 102,954.4 |

Үүнээс байгууллагын төрлөөр харуулбал:

| | | | | | |
|----------------|-----------|-----------|--|-----|-----------|
| Төрийн сан | 7,290.6 | 1,162.8 | | 0.0 | 1,162.8 |
| Төсөл, сангууд | 296,059.5 | 101,791.6 | | | 101,791.6 |

Хүснэгтээс харахад: Төрийн сан дахь дансдын үлдэгдэл 6,127.8 мянга, төсөл сангийн үлдэгдэл 194,267.9 мянган төгрөгөөр тус тус буурсан байна.

6.2 Арилжааны банкин дахь орон нутгийн харилцах дансны талаар

Төсвийн тухай хуулийн дагуу 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар арилжааны банкин дахь мөнгөн хөрөнгийн харилцах дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад Баянтал сумын орлогын дансууд эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

6.3. Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар мөнгөн хөрөнгийн зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлын талаар

Баянтал сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар мөнгөн хөрөнгийн бүртгэл, тайлагнал, зарцуулалттай холбоотой нийт **16,218.2** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **4,485.0** мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж **4,516.7** мянган төгрөгийн төлбөрийн акт бичиж, **2,384.7** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **4,831.8** төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 97.3 хувь буюу 15,775.9 мянган төгрөг нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 2.7 хувь буюу 442.5 мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Сумын мал хамгаалах сангаас өвсний орлогыг зориулалт бусаар зарцуулж 442.5 мянган төгрөгийг автомашины засварт зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Өвс, тэжээлийн үнийг зориулалтын дагуу зарцуулж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв..

- Сумын санхүүгийн албаны дотоод хяналт сул, нягтлан бодогч нар тогтвор сууршилтай ажилдаггүй зэргээс ажлын хөлс болон шагнал олгохдоо ХХОАТ-ыг суутгаагүй, ээлжийн амралтын цалинг, цалин хөлстэй давхардуулж олгосон, цалингаас суутгах НДШ-ийг дутуу суутгасан, төсвийг зориулалт бусаар зарцуулсан зөрчил дутагдал нийтлэг гарч байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 166 тоот тушаалын 1 дүгээр хавсралтын 13 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Дотоод хяналтыг сайжруулах, сумын төсвийн байгууллагуудад хяналт, шалгалт хийж байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Долоо. Авлагын бүртгэл, тайлагнал

7.1 Авлагын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд авлагын эхний үлдэгдэл 172,863.4 мянган төгрөг байсан бол тайлант онд 100.3% буюу 173,533.8 мянган төгрөгөөр нэмэгдэж оны эцэст 346,397.2 мянган төгрөгийн авлагатай тайлагнагдсан байна.

Нийт авлагын үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

| Дансны нэр, төрөл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | (мян төгрөгөөр) | |
|---------------------------------|------------------|------------------|------------------|--------------|
| | | | Зөрүү | Хувиар |
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 3,582.5 | 3,413.8 | -168.7 | 1.0 |
| Байгууллагаас авах авлага | 3,285.4 | 167,573.4 | 164,288.0 | 48.4 |
| Хувь хүмүүсээс авах авлага | 165,995.5 | 175,410.0 | 9,414.5 | 50.6 |
| НИЙТ ДҮН | 172,863.4 | 346,397.2 | 173,533.8 | 100.0 |

Хүснэгтээс харахад: нийт авлагын 48.4%-ийг байгууллагаас авах авлага, 50.6%-ийг хувь хүмүүсээс авах авлага, 1%-ийг ажиллагчидтай холбоотой авлага эзэлж байна.

Хувь хүмүүсээс авах авлагын эцсийн үлдэгдэл эхний үлдэгдлээс 3.1% буюу 10,303.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, ажиллагчидтай холбоотой авлага 4,342.8 мянган төгрөгөөр буюу 55.9%-иар буурсан байна.

Авлагыг байгууллагын төрлөөр нь дараах хүснэгтээр харуулбал:


| Байгууллага, төсөл сангийн нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Зөрүү | Хувиар | Нийт |
|--------------------------------|----------------|-----------------|-----------|--------|----------------------|
| | | | | | үлдэгдэлд эзлэх хувь |
| 4-р Сургууль | 1,857.3 | 18,837.5 | 16,980.2 | 914.2 | 5.4 |
| 4-р Цэцэрлэг | 884.8 | 2,089.1 | 1,204.3 | 136.1 | 0.6 |
| Орон нутгийн хөгжил сан | 0.0 | 163,180.0 | 163,180.0 | 0.0 | 47.1 |
| Соёлын төв | 1,679.7 | 1,911.6 | 231.9 | 13.8 | 0.6 |
| Сум хөгжүүлэх сан | 165,106.8 | 154,836.3 | -10,270.5 | -6.2 | 44.7 |
| Сумын ЗДТГ | 3,266.9 | 4,288.2 | 1,021.3 | 31.3 | 1.2 |
| Сумын ИТХ | 67.9 | 107.1 | 39.2 | 57.7 | 0.0 |

| | | | | | |
|-------------------|------------------|------------------|------------------|----------------|--------------|
| Эрүүл мэндийн төв | 0.0 | 1,147.3 | 1,147.3 | 0.0 | 0.3 |
| НИЙТ ДҮН | 172,863.4 | 346,397.1 | 173,533.7 | 1,146.9 | 100.0 |

Хүснэгтээс харахад: Сум хөгжүүлэх сангийн авлага 6.2%-иар буурч, 4-р сургуулийн авлага 914.2%-иар, 4-р цэцэрлэгийн авлага 136.1%-иар, Соёлын төвийн авлага 13.8%-иар, Сумын ЗДТГ-ын авлага 31.3 %-иар, сумын ИТХ-ын авлага 57.7 %-иар тус тус өмнөх оноос нэмэгдсэн байна.

Харин Сумын ОНХС, Эрүүл мэндийн төвүүд 2017 онд шинээр нийт 164,327.3 мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Нийт авлагад байгууллагын авлагын эзлэх хувийг диаграммаар харуулбал:



Диаграммаас харахад: нийт авлагын 47.1 хувийг сумын ОНХС, 44.7 хувийг Сумын сум хөгжүүлэх сан, 8.2 хувийг бусад нэгтгэлд орсон байгууллагын авлага эзэлж байна

7.2 Баянтал сумын ТТЗ-ийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авлагын бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:

Баянтал сумын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар авлагатай холбоотой **42,973.9** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **22,113.6** мянган төгрөгийн зөрчил дутагдлыг залруулж, **20,860.3** мянган төгрөгийн зөрчил, дутагдлыг арилгах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 94% буюу **40,382.2** мянган төгрөг нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 6% буюу **2,591.7** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Тайлант хугацаанд Сумын мал хамгаалах сангаас малчдад зээлээр 1,988.5 мянган төгрөгийн өвс, тэжээл олгосон боловч сумын ЗДТГ-ын балансад авлагаар тусгаагүй, Соёлын төв нь НДШ-ийн авлага 110.8 мянга, ХХОАТ-ын авлага 203.5 мянга, ажиллагсдаас авах авлага 288.9 мянга, нийт 603.2 мянган төгрөгийг дутуу тайлагнасан байна

Эдгээр нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Соёлын төвийн авлагыг аудитын явцад залруулж, мал хамгаалах сангаас зээлээр олгосон өвс, тэжээлийн авлагыг 2018 оны 04 дүгээр сарын 25-ны дотор багтаан залруулж, данс бүртгэлд тусгах тухай зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Найм. Бараа материалын бүртгэл, тайлагнал

8.1 Бараа материалын бүтэц, бүрэлдэхүүний талаар

Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн бараа материалын эхний үлдэгдэл 128,579.8 мянган төгрөг байсан бол эцсийн үлдэгдэл 149,937.9 мянган төгрөг болж тайлант онд бараа материалын үлдэгдэл 16.6%-иар буюу 21,358.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Бараа материалын үлдэгдлийн судалгааг хүснэгтээр үзүүлбэл:

| Бараа материалын нэр | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | (мян.төгрөгөөр) | |
|-------------------------------|-------------------|--------------------|-----------------|---------|
| | | | Зөрүү | Хувь |
| Тусгай зориулалтын материал | 35,670.8 | 49,462.2 | 13,791.4 | 38.7 |
| Эм боох материал | 4,464.0 | 5,326.4 | 862.4 | 19.3 |
| Бичиг хэргийн материал | 2,621.1 | 2,384.6 | -236.5 | -9.0 |
| Аж ахуйн материал | 26,443.9 | 29,890.5 | 3,446.6 | 13.0 |
| Сэлбэг хэрэгсэл | 85.1 | 1,285.1 | 1,200.0 | 1,410.1 |
| Түлш шатхуун, тослох материал | 1,474.5 | 420.8 | -1,053.7 | -71.5 |
| Барилга засварын материал | 438.5 | 729.4 | 290.9 | 66.3 |
| Хүнсний материал | 13,208.6 | 11,986.1 | -1,222.5 | -9.3 |
| Бусад хангамжийн материал | 44,173.3 | 48,452.8 | 4,279.5 | 9.7 |
| НИЙТ ДҮН | 128,579.8 | 149,937.9 | 21,358.1 | 16.6 |

Хүснэгтээс харахад: Тусгай зориулалтын бараа материал 13,791.4 мянга, эм боох материал 862.4 мянга, аж ахуйн материал 3,446.6 мянга, сэлбэг хэрэгсэл 1,200.0 мянга, барилгын засварын материал 290.9 мянга, бусад хангамжийн материал 4,279.5 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, бусад бараа материал 236.5-1,222.5 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд бараа материал нийт дүнгээрээ 126,714.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн ба худалдаж авсан 113,191.4 мянга, хандив тусламжаар 9,798.5 мянга, шилжүүлж авсан 3,725.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Тайлант онд бараа материал нийт дүнгээрээ 105,356.7 мянган төгрөгөөр хасагдсан нь зарцуулсан бараа материал байна.

Нийт бараа материалын үлдэгдэл 100% төсөвт байгууллагын бараа материал байна.

8.2 Баянтал сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар бараа материалын зарцуулалт, бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:

Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар бараа материалын данстай холбоотой нийт **22,625.4** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **2,072.0** мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **7,431.2** мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, **13,122.2** мянган төгрөгийн зөрчил дутагдлыг арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 54.4% буюу **12,298.4** мянган төгрөг нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 45.6% буюу **10,327.0** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- Сумын Мал хамгаалах сангаас авсан өвсний орлогыг 3,948.0 мянга, өвс, тэжээлийн зарлагыг 6,379.0 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн байна.
Энэ нь НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын ЗДТГ-ын балансад 2018 оны 04 сарын 25-ны дотор багтаан тусгах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аудитад хамрагдсан байгууллагуудын бараа материалтай холбоотой зөрчил дутагдал нь Санхүүгийн байдлын тайлан дахь бараа материалын үлдэгдэл бараа материалын тодруулгын болон дэлгэрэнгүй тайланд орлого, зарлагыг дутуу тусгах, бараа материалын орлого, зарлагын ангилалыг зөрүүтэй бүртгэсэн, хангамжийн бараа материалыг шаардах хуудсаар зарлагдах, шууд зардал болгох зэрэг бүртгэл, тайлагналтай холбоотой байна.

Эдгээр нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, Сангийн сайдын 2006 оны 388 тушаалын 1 дүгээр хавсралтын 2 дугаар зүйлийн 2.1.7, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 14 дүгээр зүйлийн 14.4.2

АОУС 210 “иж бүрэн байх”, “тодруулга ба толилуулга”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.7 дахь заалтыг зөрчсөн байна..

Ес. Үндсэн хөрөнгийн талаар

9.1. Үндсэн хөрөнгийн бүтэц, бүрэлдэхүүн, тайлагналын талаар

Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд үндсэн хөрөнгө оны эхэнд 3,551,851.1 мянган төгрөг байсан бол тайлант онд 1.47% буюу 52,512.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 3,604,363.7 төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Үндсэн хөрөнгийн үлдэгдлийн судалгааг хүснэгтээр үзүүлбэл:

| Ангилал | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Зөрүү | (мян.төгрөгөөр) |
|-----------------------|--------------------|--------------------|------------------|--------------------------------|
| | | | | Нийт хөрөнгийн дүнд эзлэх хувь |
| Барилга байгууламж | 1,652,294.4 | 1,644,131.7 | -8,162.7 | 78.3 |
| Тээврийн хэрэгсэл | 88,859.4 | 65,630.9 | -23,228.5 | 3.1 |
| Машин тоног төхөөрөмж | 153,337.6 | 120,156.0 | -33,181.6 | 5.7 |
| Тавилга эд хогшил | 109,855.1 | 98,363.9 | -11,491.2 | 4.7 |
| Дуусаагүй барилга | 10,000.0 | 10,000.0 | 0.0 | 0.5 |
| Номын фонд | 24,025.9 | 28,056.4 | 4,030.5 | 1.3 |
| Биет бус хөрөнгө | 1,498.7 | 925.7 | -573.0 | 0.0 |
| Бусад үндсэн хөрөнгө | 149,890.7 | 131,920.2 | -17,970.5 | 6.3 |
| Дүн | 2,189,761.8 | 2,099,184.8 | -90,577.0 | 100.0 |

Хүснэгтээс харахад: Нийт үндсэн хөрөнгийн 78.3%-ийг барилга байгууламж, 4.7%-ийг тавилга, эд хогшил, 5.7%-ийг машин тоног төхөөрөмж, 0.5%-ийг дуусаагүй барилга, 3.1%-ийг тээврийн хэрэгсэл, 7.7%-ийг номын фонд болон Биет бус хөрөнгө, бусад үндсэн хөрөнгө тус тус эзэлж байна.

Тайлант хугацаанд оны эхэнд нийт дүнгээрээ 3,551,851.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэлтэй байснаас 52,512.6 төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн ба үүнээс худалдан авсан 637.8 мянга, хандив тусламжаар үнэ төлбөргүй хүлээн авсан 44,322.6 мянга, шилжүүлж авсан 7,552.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдэж, 3,604.363.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Тайлант онд 1,362,089.2 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдлийн эхний үлдэгдэлтэй байснаас тайлант онд 143,089.7 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан байна.

9.2. Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар үндсэн хөрөнгийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:

ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын явцад үндсэн хөрөнгийн бүртгэл, тайлагналтай холбоотой тус тайланд нэгтгэгддэг

байгууллагуудын аудитаар нийт **18,643.7** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад зөрчил дутагдлыг залруулсан байна.

Нийт зөрчил дутагдлын 100% буюу **18,643.7** мянган төгрөг нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой байна.

Аудитад хамрагдсан байгууллагуудын үндсэн хөрөнгөтэй холбоотой зөрчил дутагдал нь үндсэн хөрөнгийн элэгдлийг дутуу тооцсон зэрэг тооцоололтой холбоотой байна.

Эдгээр нь АОУС 210 “иж бүрэн байх”, “тодруулга ба толилуулга”, “үнэн зөв байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байгаа ба Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Аж ахуйн нэгж байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө НББОУС-ын дагуу үнэлж, дансанд тусгана” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Арав. Өр төлбөрийн бүртгэл, тайлагнал

10.1 Өр, төлбөрийн бүтцийн талаар:

Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 54,766.6 мянган төгрөг байснаас тайланд онд 44.6% буюу 18,527.6 мянган төгрөгөөр нэмэгдэж, оны эцэст 73,294.2 мянган төгрөг болсон байна.

Өр, төлбөрийн үлдэгдлийн судалгааг хүснэгтээр харуулбал:

/мян төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Зөрүү | хувь |
|----------------------------------|-----------------|-----------------|-----------------|-------|
| Ажилчидтай холбоотой өглөг | 2,453.3 | 989.5 | -1,463.8 | -59.7 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 0.0 | 37.2 | 37.2 | 0.0 |
| Байгууллагад өгөх өглөг | 51,537.0 | 66,645.5 | 15,108.5 | 29.3 |
| Хүмүүст өгөх өглөг | 776.2 | 2,869.8 | 2,093.6 | 269.7 |
| Татварын өглөг | 0.0 | 2,752.2 | 2,752.2 | 0.0 |
| Нийт өр төлбөрийн дүн | 54,766.5 | 73,294.2 | 18,527.7 | |

Хүснэгтээс харахад: Ажиллагсадтай холбоотой өглөг 1,463.8 мянган төгрөгөөр буурсан бол хувь хүмүүст өгөх өглөг 2,093.6 мянга, бараа үйлчилгээний зардлын өглөг 37.2 мянга, байгууллагад өгөх өглөг 15,108.5 мянга, татварын өглөг 2,752.2 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Нийт өр төлбөрийн эцсийн үлдэгдлийг байгууллагын төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

(мян төгрөгөөр)

| № | Байгууллагуудын төрөл | Эцсийн үлдэгдэл | Нийт дүнд эзлэх |
|---|-----------------------|-----------------|-----------------|
|---|-----------------------|-----------------|-----------------|

| | | | хувь |
|---|-----------------------------------|-----------------|--------------|
| 1 | Төсөвт байгууллагууд | 24,226.8 | 33.1 |
| 2 | Төсөл сан | 49,067.4 | 66.9 |
| 3 | Төрийн сан | | |
| 4 | Тусгай шилжүүлэгийн байгууллагууд | | |
| 5 | ОНӨААТҮГ | | |
| | Дүн | 73,294.2 | 100.0 |

Хүснэгтээс харахад: нийт өр төлбөрийн 33.1%-ийг төсөвт байгууллагууд, 66.9%-ийг төсөл сан тус тус эзэлж байна.

Өмнөх онд нийт өр төлбөрийн 18.3%-ийг төсөвт байгууллага, төсөл сангийн өр төлбөр 81.7 %-ийг тус тус эзэлж байна.

Төсөл сангийн өр төлбөр орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдсэн ажлын өглөг болон барьцаа хөрөнгийн өглөг байна.

10.2 Өр, төлбөрийн бүртгэл тайлагналтай холбоотой гарсан зөрчлийн талаар:

Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудитаар өр төлбөрийн бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **1,143.6** мянгантөгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **386.9** мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **756.7** мянган төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгөв.

Дээрх **1,143.6** мянган төгрөгийн зөрчил дутагдал ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой. Үүнд:

Өр, төлбөртэй холбоотой гарч байгаа зөрчил дутагдал нь ажиллагсдын цалингаас суутгах ХХОАТ, НДШ-ийг суутган тооцсон боловч холбогдох байгууллагуудад шилжүүлдэггүй, тооцоо нийлсэн актаар баталгаажаагүй өр, төлбөрийг бүртгэж, тайлагнасан, ажил гүйлгээг тооцооны дансаар дамжуулж бүртгэдэггүйгээс өр төлбөрөө буруу тайлагнадаг зэрэг нягтлан бодогчийн ажлын хариуцлагатай холбоотой байна.

Эдгээр нь НББ-ийн тухай 5 дугаар зүйлийн 5.1.4, АОУС “үнэн зөв байх”, “толилуулга ба тодруулга”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Арван нэг. Орлогын бүртгэл, тайлагнал

11.1. Баянтал сумын ТТЗ-ын 2017 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн талаар:

Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд нийт 1,577,600.5 мянган төгрөгийн орлого, санхүүжилт бүртгэсэн байна. Энэ нь өмнөх

оноос 426,702.2 мянган төгрөгөөр буурсан байна. Нийт орлогын бууралтад үнэ төлбөргүй хүлээн авсан хөрөнгийн бууралт нөлөөлсөн байна.

Үр дүнгийн тайлангаарх орлогыг нэр төрлөөр нь харуулбал дараах байдалтай байна.

| Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он | /мян төгрөг/ | |
|--|-------------|-------------|--------------|-------|
| | | | Зөрүү дүн | хувь |
| Татварын орлого | 10,674.3 | 15,894.6 | 5,320.3 | 49.8 |
| Төсөвт байгууллагын өөрийн орлого | 1,880.6 | 5,592.1 | 3,711.5 | 197.4 |
| Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 133,378.5 | 65,398.6 | -67,979.9 | -51.0 |
| Бусад арга хэмжээ болон зээлийн хүүгийн орлого | 1,574.6 | 683.1 | -891.5 | -56.6 |
| Тусгай зориулалтын шилжүүлэг | 937,509.4 | 887,394.4 | -50,115.0 | -5.3 |
| ОНХС-гийн шилжүүлсэн орлого | 369,023.1 | 45,249.5 | -323,773.6 | -87.7 |
| Санхүүгийн дэмжлэг | 254,404.7 | 258,203.8 | 3,799.1 | 1.5 |
| Нэмэлт санхүүжилтийн орлого | 9,068.5 | 16,674.5 | 7,606.0 | 83.9 |
| Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 281,593.6 | 281,368.1 | -225.5 | -0.1 |
| Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,935.9 | 1,105.8 | -2,830.1 | -71.9 |
| Үйл ажиллагааны орлогын дүн | 2,004,302.7 | 1,577,600.5 | -426,702.2 | -21.3 |

Хүснэгтээс харахад: Орлогын бүрдүүлэлтийг өмнөх онтой харьцуулахад Татварын орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого, санхүүгийн дэмжлэг, нэмэлт санхүүжилтийн орлого тус тус нэмэгдэж, ОНХС-ийн шилжүүлгийн орлого, тусгай шилжүүлгийн орлого, зээлийн хүүгийн орлого, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийн орлого, төвлөрүүлэх шилжүүлгийн орлого тус тус буурсан байна.

11.1 Мөнгөн гүйлгээний тайлангийн болон төсвийн гүйцэтгэлийн орлогын талаар:

2017 онд Баянтал сумын ТТЗ-ийн хэмжээнд нийт 1,168,438,8 мянган төгрөгийн орлого, санхүүжилт бүрдүүлж, зарцуулахаар төлөвлөж, батлуулснаас 1,166,377.8 мянган төгрөгийн орлого, санхүүжилт бүрдүүлж, нийт орлого, санхүүжилтийн төлөвлөгөө 2,061.0 мянган төгрөгөөр тасарч сумын татварын орлогын төлөвлөгөө дутуу биелснээс Сумын ЗДТГ, ИТХ-д 2,061.0 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 1,000.0 мянган төгрөгөөр төлөвлөж гүйцэтгэлээр 1,201.6 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, төлөвлөгөөг 201.6 мянган төгрөгөөр буюу 20.1%-иар давуулан биелүүлсэн байна.

2017 онд аймгаас ОНХС-гийн санхүүжилт 45,249.5 мянга, орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг 258,203.8 мянга, нийт 303,453.3 мянган төгрөг авахаар төлөвлөж гүйцэтгэлээр санхүүжилтээ 100% авсан байна.

Өмнөх оны тэнцлийн ашиг 7,260.3 мянган төгрөгийг бүрэн төвлөрүүлсэн байна.

Мөнгөн гүйлгээний тайлангаар оны эхэнд 303,350.1 мянган төгрөгийн эхний үлдэгдэлтэй байсан ба тайлант онд нийт 1,528,328.8 мянган төгрөгийн орлого бүртгэж, үйл ажиллагааны мөнгөн гүйлгээгээр 1,504,142.1 мянга, хөрөнгө оруулалтын мөнгөн гүйлгээгээр 224,582.4 мянга, нийт 1,728,724.5 мянган төгрөгийн зарлага бүртгэж, 102,954.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Мөнгөн гүйлгээний тайланд нийт орлого 1,528,328.8 мянган төгрөгөөр тайлагнасан бөгөөд үүнээс тусламж санхүүжилтийн орлого 1,500,266.8 мянга, татварын бус орлого 12,704.7 мянга, татварын орлого 15,357.3 мянган төгрөгөөс бүрдсэн байна.

Төсвийн гүйцэтгэлийн орлого нь татварын бус орлого 5,862.1 мянга, санхүүжилтийн орлого 1,200,067.7 мянга, зээлийн эргэн төлөлтийн орлого 10,270.5 мянга, нийт 1,216,200.3 мянган төгрөгөөс бүрдсэн байна.

Нэмэлт дансны санхүүжилт нь аймгийн БСУГ-аас 4-р сургуульд хөтөлбөрийн санхүүжилт 4,704.5 мянга, АЗДНС-гаас сумын ЗДТГ-т санхүүжилт 10,400.0 мянга, АИТХ-аас ГХУСА-ын санхүүжилт 1,570.0 мянга, нийт 16,674.5 мянган төгрөгийг тус тус хүлээн авч зарцуулсан байна.

2017 онд сумын татварын орлогыг 5 төрлийн татвараар 15,550.0 мянган төгрөгөөр баталсанаас гүйцэтгэлээр 12,972.5 мянган төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 2,577.5 мянган төгрөгөөр буюу 16.5%-иар дутуу биелүүлсэн байна.

Мөн Татварын бус орлогоор 3 санд 29,517.7 мянган төгрөгийг орлогын төлөвлөгөө батлагдснаас гүйцэтгэлээр 14,661.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 14,856.7 мянган төгрөгөөр буюу 50.3%-иар дутуу биелүүлсэн байна.

11.3. Бусад эх үүсвэрийн талаар:

Сумын орлогоос гадна төсөвт зардлыг санхүүжүүлэх бусад эх үүсвэр батлагдаагүй байна.

Баянтал сумын ТТЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар орлогын бүрдүүлэлт, зарцуулалт, түүний бүртгэл тайлагналтай холбоотой нийт **17,847.2** төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **413.0** мянган төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, **17,434.2** мянган төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгөв

Нийт зөрчил дутагдлын 2.3% буюу **413.0** мянган төгрөг нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 97.7% буюу **17,434.2** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ. Үүнд:

- 2017 онд сумын татварын орлогын төлөвлөгөөг 16.5% буюу 2,577.5 мянга, татварын бус орлогын төлөвлөгөөг 50.3% буюу 14,856.7 мянган төгрөгөөр тус тус дутуу биелүүлсэн байна. Үүнд: татварын орлогыг 5 төрлийн татвараар 15,550.0 мянган төгрөг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 12,972.5 мянга, татварын бус орлогоор 3 санд 29,517.7 мянган төгрөгийг орлогын төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 14,661.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Орлогын төлөвлөгөөг бодит тоо мэдээнд үндэслэн үнэн зөв төлөвлөж батлуулах, орлогын төлөвлөгөөг биелүүлэхэд анхаарч байгууллагын нөөц бололцоог дайчлан ажиллах зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Мөн аймгийн Засаг даргын 2017.05.15-ны 02/526 дугаартай албан бичгээр сумын Мал хамгаалах сан, Байгаль хамгаалах сангуудыг төсвийн тодотгол хийхдээ татан буулгаж холбогдох арга хэмжээг авч, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах талаар чиглэл хүргүүлсэн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Аудитын явцад орлогын бүрдүүлэлт, бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчил дутагдал нь орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн төлөвлөөгүй, орлогын төлөвлөгөөг биелүүлээгүй, үйл ажиллагааны орлогыг бүртгээгүй, шууд зарцуулах, сум хөгжүүлэх сангийн зээлийн алданги, хүүгийн орлогыг тооцож бүртгээгүй, ажилтаны цалингаас суутгасан сахилгын арга хэмжээний орлогыг бүртгээгүй зэрэг алдаа, зөрчлүүд байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Арван хоёр. Зардлын бүртгэл, тайлагнал

12.1. Зардлын бүтцийн талаар:

2017 онд Баянтал сумын ТТЗ-ийн тайлант онд анх сумын 6 төсвийн байгууллагад 1,131,791.6 мянган төгрөгийн төсөв батлагдаж, 2 удаагийн төсвийн тодотголоор нийт 37,647.2 мянган төгрөгөөр нэмэгдэж, 1,169,438,8 мянган төгрөгийн төсөв батлагдсан байна.

Төсвийн тодотголоор төрийн албан хаагчийн үр дүнгийн урамшуулал 18,753.3 мянга, цалингийн зардал 6,375.1 мянга, сонгуулийн үр дүнгээр ажлаас халагдсан ажилтны тэтгэмж 8,228.2 мянга, урсгал засвар 3,790.6 мянга, сурталчилгааны зардал 500.0 мянга, нийт 37,647.2 мянган төгрөг нэмэгдсэн байна.

Тайлант онд төсвийн 6 байгууллага урсгал үйл ажиллагааны зардалд 1,169,438.8 мянган төгрөгийг зарцуулахаас 1,155,497.5 мянган төгрөгийг зарцуулж, 13,941.3 мянган төгрөгийг хэмнэсэн бөгөөд сумын ерөнхий орлогод 1,105.8 мянга, улсын төсөвт 12,835.5 мянган төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

12.2 Баянтал сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой зөрчлүүдийн талаар:

Баянтал сумын ТТЗ-ийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой нийт **32,445.6** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрснээс аудитын явцад **19,710.9** мянган төгрөгийн алдаа, зөрчлийн залруулга хийж, **12,734.7** мянган төгрөгийн алдаа, зөрчил арилгуулах зөвлөмж өгөв.

Нийт зөрчил дутагдлын 67.2% буюу **21,779.9** мянган төгрөг нь ТТЗ-ийн тайланд нэгтгэгдсэн байгууллагуудтай холбоотой ба нэгтгэсэн тайланг аудитлах явцад 32.8% буюу **10,665.7** мянган төгрөгийн зөрчил дутагдал илэрлээ Үүнд:

- Төсвийн тодотголоор Сумын ИТХ-ын цалингийн зардлыг 6,375.1 мянга, ЗДТГ-ын урсгал засвар 3,790.6 мянга, сурталчилгааны зардал 500.0 мянга, нийт 10,665.7 мянган төгрөгөөр тодотгож төсвийг үндэслэлгүй нэмэгдүүлэн баталж, төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.5, 6.4.1 дэх заалт, Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоолуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн жилийн дундуур орлого бууруулах, зарлага оны нэмэгдүүлэх үр дагавартай бодлогын аливаа шийдвэр гаргасан бол түүнийг дараагийн төсвийн жилээс хэрэгжүүлдэг байх, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Аудитаар төсвийн зарцуулалт, бүртгэл, тайлагналтай холбоотой дараах нийтлэг алдаа зөрчил дутагдал илэрсэн байна. Тухайлбал: цалингийн зардлыг илүү дутуу бүртгэсэн, ОНХС-ийн болон хөрөнгийн зардлаас дэд хөтөлбөр нэрээр урсгал зардлуудыг санхүүжүүлсэн, зардлын зүйл ангийг буруу ангилж бүртгэх, ажилчдад олгосон цалингийн цэсэнд ажилчдаар гарын үсэг зуруулаагүй, зардлын ангиллыг өөр нэрээр бүртгэсэн зэрэг алдаа зөрчлүүд илэрсэн байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.3, 6 дугаар зүйлийн 6.6.2, 6.3.2, 6.4.1, 16.5.5, НББ-ийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5, ХХОАТ-ын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Арван гурав. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой гарсан зөрчлүүдийн талаар:

